



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 09 өдөр

Дугаар А/341

Мандалговь

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх
шийдвэрт өөрчлөлт оруулах тухай

"Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль"-ийн 5.1.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. ITRF-97 солбицолын тогтолцоонд хийгдсэн кадастрын зургийг UTM тусгагт хөрвүүлэхэд систем хоорондын зөрүүнээс үүдэж эдлэн газрын кадастрын зургийн талбайн хэмжээ зөрүүтэй гарч байгаа болон Хаягжуулалтын тухай хуулийн дагуу шинэ хаяг авсан 7 нэгж талбарын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Кадастрын зургийн талбайн хэмжээ, хаягийн өөрчлөлтийг аливаа шилжилт хөдөлгөөн хийлгэхээр газар өмчлөгч хүсэлт гаргасан тухай бүр шийдвэрлүүлж газрын улсын бүртгэлд өөрчлөлт оруулах иргэд олон нийтэд мэдээлэл өгч ажиллахыг Сайнцагаан сумын Засаг дарга (С.Бат-Оргил), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Газрын талбайн хэмжээний өөрчлөлтийг тухай бүр гарсан шийдвэрийг үндэслэн газар өмчлөгч иргэдэд хүндрэл, чирэгдэлгүй, хууль тогтоомжид заасны дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Улсын бүртгэл хэлтэс (Ж.Өлзийжаргал)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2005 оны 319 дүгээр захирамжийн хавсралтын 434 дэх хэсэг, 2013 оны А/484 дүгээр захирамжийн хавсралтын 10 дахь хэсэг, 2015 оны А/349 захирамжийн хавсралтын 1 дэх хэсэг, 2017 оны А/122 захирамжийн хавсралтын 4 дэх хэсэг, 2021 оны А/76 дугаар захирамжийн хавсралтын 3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210830